



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: [Sunjidmaae@audit.gov.mn](mailto:Sunjidmaae@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есенбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.08.14 № 82

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.УУГАНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын төвийн нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажил 2022-2025 онд хийгдэж барилгын болон холболтын ажил дууссан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд гүйцэтгэлээр 1,129,294.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 7.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Бусад асуудал**

Тайлант онд 3 хөтөлбөр, 6 зорилт, 89 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 60 арга хэмжээг бүрэн, 15 арга хэмжээг 70 хувь, 7 арга хэмжээг 50 хувь, 4 арга хэмжээг 30 хувь, хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс болж тасарсан

хэрэгжилтийг тооцох боломжгүй 3 арга хэмжээ байна. Нийт дүнгээр 80.1 хувиар үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>449,515,618.19</u></b>	<b><u>405,697,627.19</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	47,488,948.00	7,488,948.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	47,488,948.00	7,488,948.00
33510	Байгууллагаас авах авлага	46,500,000.00	6,500,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	988,948.00	988,948.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	402,026,670.19	398,208,679.19
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	37,000,002.00	37,000,002.00
35110	Тусгай зориулалттай материал	37,000,002.00	37,000,002.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	140,350,108.19	136,532,117.19
35410	Бичиг хэргийн материал	667,000.00	667,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,440,000.00	9,735,000.00
35470	Бусад хангамжийн материал	129,243,108.19	126,130,117.19
35600	Мал амьтад	224,676,560.00	224,676,560.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,306,797,044.61</u></b>	<b><u>2,435,323,097.48</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,306,797,044.61	2,435,323,097.48
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,207,035,044.61	2,335,561,097.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,095,953,124.00	2,115,802,617.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(431,107,550.28)	(499,914,173.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	396,295,000.00	625,295,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(294,534,322.57)	(330,191,614.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,657,080.00	256,631,341.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,604,301.39)	(113,100,816.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	288,970,453.00	283,185,953.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,631,667.26)	(87,785,922.43)
39209	Зам, гүүрний байгууламж	23,032,000.00	23,032,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(3,763,870.89)	(6,420,720.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,769,100.00	69,269,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(241,666.60)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	99,762,000.00	99,762,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	99,762,000.00	99,762,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,756,312,662.80</u></b>	<b><u>2,841,020,724.67</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>1,494,633.48</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,494,633.48
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,494,633.48
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	359,719.98
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,134,913.50
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,134,913.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,756,312,662.80</u></b>	<b><u>2,839,526,091.19</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,756,312,662.80	2,839,526,091.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,189,424.37	296,189,424.37

51101	Өмч: - төрийн	296,189,424.37	296,189,424.37
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,458,016,121.53</b>	<b>2,541,229,549.92</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,090,238,442.73	2,458,016,121.53
51220	Тайлант үеийн үр дүн	367,777,678.80	83,213,428.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,107,116.90	2,107,116.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,756,312,662.80</b>	<b>2,841,020,724.67</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,711,282,148.00</b>	<b>1,439,201,291.93</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>528,519,659.00</b>	<b>302,484,461.93</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>528,519,659.00</b>	<b>302,410,000.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	499,662,159.00	301,960,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,592,500.00	450,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	74,461.93
122001	Хандив тусламж /дотоод/	-	74,461.93
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,182,762,489.00</b>	<b>1,136,716,830.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>129,375,589.00</b>	<b>7,421,880.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	127,289,589.00	1,721,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,086,000.00	5,700,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,053,386,900.00</b>	<b>1,129,294,950.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,053,386,900.00	1,129,294,950.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,298,273,385.90</b>	<b>1,344,354,863.61</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,298,273,385.90</b>	<b>1,344,354,863.61</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,111,248,734.25</b>	<b>1,099,564,720.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>579,754,066.00</b>	<b>645,719,775.70</b>
210101	Үндсэн цалин	272,531,497.00	312,727,576.46
210102	Нэмэгдэл	205,904,073.00	233,388,073.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,373,000.00	18,655,000.00
210104	Урамшуулал	29,289,120.00	23,895,878.04
210105	Гэрээт ажлын хөлс	60,656,376.00	57,053,247.78
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>68,856,890.52</b>	<b>79,563,981.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,601,790.52	54,919,627.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,313,800.00	6,211,929.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,656,900.00	3,105,965.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,656,900.00	3,036,776.02
210205	Эрүүл мэндийн даатгал	10,627,500.00	12,289,683.64

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,438,285.32	35,386,400.40
210301	Гэрэл, цахилгаан	14,284,285.32	7,891,400.40
210302	Түлш, халаалт	15,154,000.00	26,995,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,895,364.51	54,083,347.50
210401	Бичиг хэрэг	2,796,850.00	3,628,050.30
210402	Тээвэр, шатахуун	48,917,059.00	42,237,106.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,506,955.51	1,723,500.00
210404	Ном, хэвлэл	-	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,624,500.00	2,841,700.00
210408	Бараа материал акталсны зардал	1,470,000.00	3,562,991.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	1,595,000.00	102,000.00
210502	Хоол, хүнс	510,000.00	102,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,652,200.00	21,966,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	995,000.00
210604	Урсгал засвар	19,652,200.00	20,971,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	20,670,000.00	19,900,000.00
210702	Дотоод албан томилолт	20,670,000.00	19,900,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	52,488,366.00	4,358,906.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,565,000.00	2,983,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,300.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	573,904.00	202,356.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	585,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	281,898,561.90	238,483,809.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,122,600.00	28,113,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,500.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	175,635,461.90	210,290,709.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	187,024,651.65	244,790,143.24
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	68,094,273.00	40,761,005.90
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,142,214.00	39,681,005.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,395,039.00	1,080,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	118,930,378.65	204,029,137.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,328,739.65	203,814,137.34
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,601,639.00	215,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>413,008,762.10</b>	<b>94,846,428.32</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	45,231,083.30	11,632,999.93
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	45,231,083.30	11,632,999.93
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(45,231,083.30)	(11,632,999.93)

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>367,777,678.80</u>	<u>83,213,428.39</u>
---	-------------------------	-----------------------	----------------------

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,182,762,489.00</u></b>	<b><u>1,136,716,830.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>1,182,762,489.00</u></b>	<b><u>1,136,716,830.00</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	129,375,589.00	7,421,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	127,289,589.00	1,721,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,086,000.00	5,700,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,053,386,900.00	1,129,294,950.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,053,386,900.00	1,129,294,950.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,142,746,089.00</u></b>	<b><u>1,128,301,530.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,142,746,089.00</u></b>	<b><u>1,128,301,530.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>966,002,576.35</u></b>	<b><u>883,511,386.76</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	570,597,901.00	645,719,775.70
210101	Үндсэн цалин	263,375,332.00	312,727,576.46
210102	Нэмэгдэл	205,904,073.00	233,388,073.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,373,000.00	18,655,000.00
210104	Урамшуулал	29,289,120.00	23,895,878.04
210105	Гэрээт ажлын хөлс	60,656,376.00	57,053,247.78
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,328,859.52	79,204,261.66
210201	Тэтгэврийн даатгал	48,073,759.52	54,559,907.72
210202	Тэтгэмжийн даатгал	5,313,800.00	6,211,929.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,656,900.00	3,105,965.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,656,900.00	3,036,776.02
210205	Эрүүл мэндийн даатгал	10,627,500.00	12,289,683.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,908,285.32	34,681,400.40
210301	Гэрэл, цахилгаан	14,284,285.32	7,891,400.40
210302	Түлш, халаалт	22,624,000.00	26,290,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,759,364.51	49,385,443.00
210401	Бичиг хэрэг	2,796,850.00	2,593,000.00
210402	Тээвэр, шатахуун	48,917,059.00	42,237,243.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,506,955.51	1,723,500.00
210404	Ном, хэвлэл	-	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,958,500.00	2,741,700.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	1,595,000.00	102,000.00
210502	Хоол, хүнс	510,000.00	102,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,933,700.00	21,966,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	995,000.00
210604	Урсгал засвар	20,933,700.00	20,971,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	20,670,000.00	19,900,000.00

210702	Дотоод албан томилолт	20,670,000.00	19,900,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>52,488,366.00</b>	<b>4,358,906.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,565,000.00	2,983,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,300.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	573,904.00	202,356.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.00	585,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>136,721,100.00</b>	<b>28,193,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,580,600.00	28,113,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	140,500.00	80,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>176,743,512.65</b>	<b>244,790,143.24</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>57,813,134.00</b>	<b>40,761,005.90</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,142,214.00	39,681,005.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,113,900.00	1,080,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>118,930,378.65</b>	<b>204,029,137.34</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,328,739.65	203,814,137.34
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,601,639.00	215,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>40,016,400.00</u></b>	<b><u>8,415,300.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>46,281,400.00</b>	<b>8,415,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>46,281,400.00</b>	<b>8,415,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>46,281,400.00</b>	<b>8,415,300.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,281,400.00	8,415,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(46,281,400.00)</u></b>	<b><u>(8,415,300.00)</u></b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

( төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	2,090,238,442.73	2,388,534,984.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>296,189,424.37</b>	<b>2,107,116.90</b>	<b>2,090,238,442.73</b>	2,388,534,984.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>296,189,424.37</b>	<b>2,107,116.90</b>	<b>2,458,016,121.53</b>	2,756,312,662.80
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>296,189,424.37</b>	<b>2,107,116.90</b>	<b>2,458,016,121.53</b>	2,756,312,662.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>296,189,424.37</b>	<b>2,107,116.90</b>	<b>2,458,016,121.53</b>	2,756,312,662.80

D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	83,213,428.39	83,213,428.39
D09	20125 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>296,189,424.37</b>	<b>2,107,116.90</b>	<b>2,541,229,549.92</b>	2,839,526,091.19

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,129,294,950.0</b>	<b>925,480,812.7</b>	203,814,137.3	82.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,129,294,950.0	1,129,294,950.0	203814137.3	82.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,076,680,750.0	884,719,806.76	191,960,943.2	82.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	775,511,580.0	645,397,428.70	130,114,151.3	83.2
210101	Үндсэн цалин	311,636,790.0	312,405,229.46	(768,439.5)	100.2
210102	Нэмэгдэл	255,470,990.0	233,388,073.42	22,082,916.6	91.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,360,000.0	18,655,000.00	11,705,000.0	61.4
210104	Урамшуулал	32,233,200.0	23,895,878.04	8,337,322.0	74.1
210105	Гэрээт ажлын хөлс	145,810,600.0	57,053,247.78	88,757,352.2	39.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	96,835,070.0	79,204,261.66	17,630,808.3	81.7
210201	Тэтгэврийн даатгал	65,814,610.0	54,559,907.72	11,254,702.3	82.9
210202	Тэтгэмжийн даатгал	7,755,120.0	6,211,929.26	1,543,190.7	80.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,204,090.0	3,105,965.02	3,098,125.0	50.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,551,020.0	3,036,776.02	(1,485,756.0)	195.7
210205	Эрүүл мэндийн даатгал	15,510,230.0	12,289,683.64	3,220,546.4	79.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,812,000.0	34,681,400.40	1,130,599.6	96.8
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.0	7,891,400.40	1,108,599.6	87.6
210302	Түлш, халаалт	26,312,000.0	26,290,000.00	22,000.0	99.9
210303	Цэвэр, бохир ус	500,000.0	500,000.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,802,000.0	48,195,910.00	14,606,090.0	76.7
210401	Бичиг хэрэг	5,000,000.0	2,593,000.00	2,407,000.0	51.8
210402	Тээвэр, шатахуун	50,302,000.0	41,167,710.00	9,134,290.0	81.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.0	1,603,500.00	2,396,500.0	40.0

210404	Ном, хэвлэл	500,000.0	90,000.00	410,000.0	18.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.0	2,741,700.00	258,300.0	91.3
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	510,000.0	102,000.00	408,000.0	20.0
210502	Хоол, хүнс	510,000.0	102,000.00	408,000.0	20.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,000,000.0	29,381,800.00	1,618,200.0	94.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.0	8,410,300.00	1,589,700.0	84.1
210604	Урсгал засвар	21,000,000.0	20,971,500.00	28,500.0	99.8
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	28,026,000.0	19,900,000.00	8,126,000.0	71.0
210702	Дотоод албан томилолт	28,026,000.0	19,900,000.00	8,126,000.0	71.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,184,100.0	4,358,906.00	9,825,194.0	30.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,709,100.0	2,983,000.00	5,726,100.0	34.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.0	403,200.00	796,800.0	33.6
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	64,350.00	235,650.0	21.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,000.0	202,356.00	622,644.0	24.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.0	121,000.00	29,000.0	80.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.0	585,000.00	2,415,000.0	19.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,000,000.0	23,498,100.00	8,501,900.0	73.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.0	23,418,100.00	6,581,900.0	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.0	80,000.00	1,920,000.0	4.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	52,614,200.00	244,575,143.24	(191,960,943.2)	464.8
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	52,614,200.0	40,761,005.90	11,853,194.1	77.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,733,200.0	-	8,733,200.0	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,681,000.0	39,681,005.90	1,999,994.1	95.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.0	1,080,000.00	1,120,000.0	49.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,129,294,950.0</b>	<b>925,480,812.7</b>	203,814,137.3	82.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,129,294,950.0	<b>925,480,812.7</b>	203,814,137.3	82.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,129,294,950.0	<b>925,480,812.7</b>	203,814,137.3	82.0

## 2.6 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,421,880.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	7,421,880.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,206,880.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	322,347.00
210101	Үндсэн цалин	322,347.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,189,533.00
210402	Тээвэр, шатахуун	1,069,533.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,695,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,695,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	215,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	215,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,421,880.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,421,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,721,880.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,700,000.00

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар 1,066,325.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүжилтийг зөрүүтэй тайлагнасан 134,123.5 мянган төгрөг, нэмэлтийн орлогыг 770.4 мянган төгрөгөөр дутуу, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын тайланд 33,000.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээ, үр дүнгийн зардлыг 1,296.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

**Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 843,299.6 мянган төгрөгийн 17 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 54,362.0 мянган төгрөгийн 13 мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад нөхөн тайлагнуулсан.

Залруулагдаагүй 12,276.4 зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 12,276.4 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 зөрчил арилгах албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Албан шаардлага

1. Өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтны төрд ажилласан жилийг зөрүүтэй тооцож 8,713.5 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгож журам"-ын 3 дугаар зүйл 3.1.12-т "Нийгмийн шилжилтийн явцад ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний 1990-1995 оны хооронд ажилласан жил тасарсан иргэнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас зохих журмын дагуу олгосон баталгаажилтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацаа", 5 дугаар зүйлийн 5.4-д "Төрийн албан хаагчийн ажиллаж байсан байгууллагын дарга, хүний нөөц болон санхүү хариуцсан ажилтнууд энэ журмын дагуу тухайн төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаа, үндсэн цалинг үнэн зөв тодорхойлох үүрэг хүлээнэ." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тэтгэвэр, тэтгэмжийн тооцоололд дотоод хяналт шалгалт хийн зөрчлийг арилгах арга хэмжээ авах.

2. Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2023 оны 02/44 дугаар, 2025 оны 01/49, 02/49 дугаар төлбөрийн актын биелэлтийг хангуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ууганбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

Илрүүлэлт: Барилга байгууламж дансанд худаг, цооног, мал угаалгын байн, явган хүний зам, бохирын болон дулааны шугам, услалтын систем, шилэн кабель, хөшөө зэрэг 1,192,824.4 мянган төгрөгийн, тоног төхөөрөмж дансанд нам даралтын зуух, гэрэлтүүлэг, хаяг зэрэг 62,857.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгэх.

### **Хоёр. Хууль тогтоомжтой холбоотой**

Илрүүлэлт: Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн шийдвэргүй, Тамгын даргын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/37 дугаар тушаалаар 3,562.9 мянган төгрөгийн бараа материалыг акталсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын хавсралт "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам" 2 дугаар зүйлийн 2.2.6.-д “Зөвлөл нь санал боловсруулах, дүгнэлт гаргах, шийдвэр хэрэгжүүлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан бүртгэл, мэдээллийн маягт болон хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх, ашиглалтаас хасах, устгах, худалдахтай холбоотой дараах баримт материалыг бүрдүүлэн хадгалж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллана”, 4 дүгээр зүйлийн 4.3-т “Тооллогын дүнгээр бүртгэлд тусгаагүй хөрөнгийн ТӨ-9, дутагдсан ТӨ-10, маргаантай хөрөнгийн ТӨ-11, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн ТӨ-12 маягтыг бүрдүүлж, шалтгаан нөхцөлийг тогтоож дүгнэлт гаргана”, гэж заасантай, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, шийдвэрийн дагуу акталж байх.

### **Гурав. Хууль тогтоомжтой холбоотой**

Илрүүлэлт: Өмнөх оны тооцоо нийлээгүй 7,488.9 мянган төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тулган баталгаажуулаагүй, барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газар	Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 843,299.6 мянган төгрөгийн 17 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 54,362.0 мянган төгрөгийн 13 мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад нөхөн тайлагнууллаа.	1	897,661.5	1	897,661.5	-	-	1	897,661.5	-	-	-	-
	Санхүүжилтийг зөрүүтэй тайлагнасан 134,123.5 мянган төгрөг, нэмэлтийн орлогыг 770.4 мянган төгрөгөөр дутуу, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын тайланд 33,000.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээ, үр дүнгийн зардлыг 1,296.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	186,663.9	-	-	1	186,663.9	1	186,663.9	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>1,066,325.5</b>	<b>1</b>	<b>897,661.5</b>	<b>1</b>	<b>186,663.9</b>	<b>2</b>	<b>1,066,325.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газар	Барилга байгууламж дансанд худаг, цооног, мал угаалгын байн, явган хүний зам, бохирын болон дулааны шугам, услалтын систем, шилэн кабель, хөшөө зэрэг 1,192,824.4 мянган төгрөгийн, тоног төхөөрөмж дансанд нам даралтын зуух, гэрэлтүүлэг, хаяг зэрэг 62,857.0 мянган хөрөнгийг тус тус дансны ангилал зөрүүтэй бүртгэсэн.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-
	Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй Тамгын даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар 3,562.9 мянган төгрөгийн бараа материалын акталсан.	1	3,562.9	-	-	-	-	-	1	3,562.9	-	-
	Өмнөх оны тооцоо нийлээгүй 7,488.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-
	Өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтны төрд ажилласан жилийг зөрүүтэй тооцож 8,713.5 мянган төгрөгийг илүү олгосон.	1	8,713.5	-	-	-	1	8,713.5	-	-	-	-
	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2023 оны 02/44 дугаартай 16,772.0 мянган төгрөгийн, 2025 оны 01/49, 02/49 дугаартай 178.5 мянган төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй.	1	-	-	-	-	-	-	-	-	1	-
<b>Нийт</b>		<b>5</b>	<b>12,276.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>8,713.5</b>	<b>3</b>	<b>3,562.9</b>	<b>1</b>		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

ГAA-2026/124/HA-CTA-TШ3